

ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧИЙН ҮГ

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Олон улс судлал” сэтгүүл нь 44 дэх жилдээ тасралтгүй хэвлэгдэн гарч буй бөгөөд өнөөдөр №113 дахь дугаараа уншигч таны гарт өргөн барьж байгаадаа баяртай байна.

Энэ дугаарт гадаад харилцааны мэргэжилтнүүд, эрдэм шинжилгээний байгууллагын ажилтан, их сургуулийн багш зэрэг дотоод, гадаадын судлаачдын бичсэн өгүүлэл, нийтлэлүүдийг багтаалаа.

Сэтгүүлийн редакц 2021 оны сүүлийн хагаст эрдэм шинжилгээний өгүүлэл хүлээн авах журмынхаа дагуу нийт 16 өгүүллийг судлаач эрдэмтэдээс хүлээн авав. Эдгээрээс редакцын анхан шатны үнэлгээ, хөндлөнгийн шинжээчийн шүүмж, редакцын зөвлөлийн хуралдааны шийдвэр гэсэн гурван шатны үнэлгээнд үндэслэн эрдэм шинжилгээний өгүүлэл 3, тойм нийтлэл 1, номын шүүмж 1-ийг сонгон авч, 3 шинэ номын мэдээтэй хамтатган хэвлүүлж байна.

Хэвлэгдсэн өгүүлэл, тойм нийтлэл, номын шүүмжүүд тус бүр хөндлөнгийн шинжээчийн шүүмжийн дагуу сайжруулагдсан ба үүнээс 2 өгүүлэл давтан буцаж засварлагдсан болохыг онцлон тэмдэглэхийн ялдамд сэтгүүлд нийтлүүлсэн материалуудыг чанаржуулахад үнэт цагаасаа хугаслан шүүмж бичиж ирүүлсэн шинжээч нартаа гүнээ талархаж байна.

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Гуравдагч хөрш орон судлалын салбарын эрхлэгч, доктор, дэд профессор Ч.Цэрэннадмидын “Бүгд Найрамдах Турк Улс дахь улс төрийн намын үүсэл, хөгжил” хэмээх өгүүлэл энэ удаагийн дугаарт хэвлэгдлээ. БНТУ дахь улс төрийн намуудын үүсэл, хөгжлийн талаар тэр дундаа Бүгд Найрамдах улс байгуулагдсан цаг үе буюу Туркийн дотоод улс төрийн амьдралд М.К.Ататуркээр удирдуулсан улс төрийн хүчнээс гадна үзэл, хандлагаараа ялгаатай нийгмийн бүлгүүд үүсэж, оршин байхын төлөө тэмцэж, зарим тохиолдолд хүчээр хаагдах хүртэл олон үйл явдал өрнөсөн, өвөрмөц үеийг энэхүү өгүүлэлдээ сонгон судалсан байна. Чингэхдээ зохиогч Туркэд сонгодог утгаараа улс төрийн анхны нам үүссэн шалтгаан, түүхэн нөхцөлийг харуулах, мөн ХХ зууны Туркийн улс төрийн намын үйл ажиллагааг зохицуулж байсан хууль, эрх зүйн орчны онцлогийг харуулах, түүнчлэн олон намын тогтолцоо үүсэн, бүрэлдсэн нөхцөлийг тодотгох, 1990 оноос хойших Туркийн улс төрийн намын тогтолцооны төлөвшил, онцлогийг тус тус харуулахыг зорьжээ.

БНХАУ-ын Өвөр Монголын Их сургуулийн Монгол судлалын төвийн судлаач, доктор Б.Шүрэнтанын “Хятадын талаарх монголчуудын ойлголтын тухай судалгааны тойм” өгүүлэл та бүхний сонирхлыг татна

гэдэгт итгэлтэй байна. Тэрээр Монгол, Хятадын эрдэм шинжилгээний байгууллагууд харилцан ашигтай, хамтын ажиллагааг шат ахиулахад бодит хувь нэмэр оруулах шаардлагатай бөгөөд ингэснээрээ хоёр талын харилцаанд сургамж болсон зарим жишээг салбар бүрээр олон талаас нь дүгнэн шинжилж, талуудын харилцах явцад үүсдэг сэтгэлзүйн болон сэтгэлгээний асуудлыг иж бүрнээр сайтар судалж, харилцан ойлголцол, итгэлцлийг хэрхэн гүнзгийрүүлэх тухайд судалгаанд суурилсан бодлогын зөвлөмжийг боловсруулах шаардлагатай байгааг тодруулжээ.

Монгол Улсын Хүмүүнлэгийн ухааны Их сургуулийн багш, доктор Т.Чулуун-Эрдэнэ “ХКН-ын XVIII их хурлаас хойших Хятад улсын гадаад бодлогын шинэ үзэл санаа ба Монгол, Хятадын харилцаа” өгүүлэлдээ уг хурлаас хойших Хятадын гадаад бодлогын шинэ үзэл санаа, тэр дундаа хөрш зэргэлдээ улс орнуудад хандан хэрэгжүүлж буй “Ойр дотно, чин сэтгэлийн, харилцан ашигтай, уужуу хүртээмжтэй байх” ба “Хүн төрөлхтний хувь заяаны цогц нэгдэл” хэмээх гадаад бодлогын ойлголтын талаар танилцуулж, 2012-2021 онд Монгол, Хятад хоёр улсын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд болсон үйл явдал, тэр дундаа аюулт цар тахлын эсрэг хамтдаа тэмцсэн хийгээд хоёр талын харилцан бие биедээ тусалж дэмжиж ирсэн түүхийг хэрхэн тайлбарласныг сонирхоно уу.

Редакц энэ удаагийн дугаартаа

профессор Д.Баярхүүгийн “Тэсрэлт: «Европын Ким Чен Ун» гэгдэх Беларусь Батька” тойм нийтлэлийг онцолж байна. Түүний нийтлэлд Зүүн Европын халуун цэг болоод буй Беларусь, ямар учир шалтгааны улмаас олон улсын анхаарлын төвд ороод байгааг Өрнөдийн болон Оросын улс төрчид, судлаачдын тайлбарт үндэслэн сонирхолтойгоор тоймлон өгүүлсэнтэй танилцаж болно.

МУИС-ийн багш, доктор С.Баясгалан Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн 30 жилийн ойн хүрээнд хэвлэгдсэн олон бүтээлийн нэг болох доктор Ж.Борын “Монгол Улсыг хүрээлэн буй геополитик, геостратегийн гадаад орчин: өнгөлөн далдлалт, төөрөгдүүлэлт, бодит байдал, хашлага давах боломж” номонд шүүмж өгсөн байна. Тэрээр шүүмжээрээ дамжуулан өргөн олон уншигч түмэнд орчин цагийн олон улсын харилцааны аливаа асуудлыг гагцхүү Оросын болон Барууны улс орнуудын өнцгөөс харах нь учир дутагдалтай байдаг тул үндэсний сэхээтнийхээ бичсэн Монгол Улсад тулгарч буй геополитикийн сорилтуудын талаарх уг бүтээлтэй танилцаж, оюуны цэнгэл хүртэхийг уншигчдад санал болгожээ.

Сэтгүүлийнхээ шинэ номын танилцуулга хэсэгт манай хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын 2021 онд эрхлэн гаргасан “Монгол-Оросын харилцаа он дарааллын товчоон (1911-2011)”, “Монгол Улс, БНСУ-ын харилцаа, баримт бичгийн эмхэтгэл (1990-2019)”, “Монгол Улс, БНСУ-ын харилцаа он дарааллын

товчоон (1990-2019)” хийгээд хятад судлаач, докторант Х.Баатархүүгийн “Улаанхүү” номын танилцуулгуудыг тус тус хүргэж байна.

Дашрамд өгүүлэхэд, манай хүрээлэнгээс эрхлэн гаргаж байсан сэтгүүлүүдэд 1978-1999 онд хэвлэгдсэн нийт 800 гаруй өгүүлэл, нийтлэлийг www.mori.ac.mn нээлттэй цахим мэдээллийн сангаас танилцах боломжтой болсон гэдгийг Та бүхэнд дуулгахад таатай байна.

2022 оноос эхлэн манай сэтгүүл хэвлүүлэхээр ирүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийг сэтгүүлийн редакц хүлээн авснаас хэвлэгдэх хүртэлх хугацаан дахь хяналтын аль шатанд явж буйг зохиогчид нь нээлттэйгээр харж болохоор зохицуулагдсан цахим хэлбэрт

шилжиж байгаа юм.

Иймд сэтгүүлийн дараагийн дугаарт өгүүлээ хэвлүүлэх хүсэлтэй эрхэм судлаач, бичгийн мэргэд Та бүхэн <https://www.mongoliajol.info/index.php/index/user/register> хуудсанд өөрийн нэрээр эрх үүсгэн бүртгүүлж, судалгааны бүтээлээ илгээвэл Редакцын зөвлөл болон судлаач, хөндлөнгийн шинжээч нарын хамтын ажиллагаанд илүү хялбар, хөнгөн шуурхай байх болно гэдгийг дуулгахдаа таатай байна.

Манай сэтгүүлд холбогдох санал, сэтгэгдэлээ mjis@mas.ac.mn хаягаар ирүүлэхийг хүсье.

Сэтгүүлийн ерөнхий эрхлэгч